

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/204/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН БҮЖИНХЭН ЦОГЦОЛБОР
ЦЭЦЭРЛЭГ ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага.....	18
4.4 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/80
танай -ны № -Т

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
БҮЖИНХЭН ЦОГЦОЛБОР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ч.ГАНПҮРЭВ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020271

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,240,224.73	69,232,463.80
35	БАРАА МАТЕРИАЛ	64,240,224.73	69,232,463.80
351	Түүхий эд материал	31,500.00	235,850.00
35130	Эм боох материал	31,500.00	235,850.00
354	Хангамжийн материал	64,208,724.73	68,996,613.80
35410	Бичиг хэргийн материал	00.00	410,700.00
35420	Аж ахуйн материал	2,487,530.00	1,733,050.00
35460	Хүнсний материал	2,406,931.00	2,608,435.00
35470	Бусад хангамжийн материал	59,044,213.73	64,244,428.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	979,526,482.04	1,249,911,219.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	979,526,482.04	1,249,911,219.78
392	Биет хөрөнгө	774,691,682.04	1,045,130,389.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	778,138,610.00	1,079,888,957.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-60,185,848.04	-92,830,180.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,093,100.00	50,563,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,335,769.34	-25,700,741.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,037,677.74	52,347,177.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,056,088.32	-19,137,923.09
393	Биет бус хөрөнгө	204,834,800.00	204,780,829.97
39301	Программ хангамж	359,800.00	359,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-53,970.03
39303	Бусад биет бус хөрөнгө	204,475,000.00	204,475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,043,766,706.77	1,319,143,683.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,043,766,706.77	1,319,143,683.58
51	Засгийн газрын хувь оролцоо	1,043,766,706.77	1,319,143,683.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	529,803,122.18	529,803,122.18
51101	Өмч: - төрийн	204,475,000.00	204,475,000.00
51102	- хувийн	325,328,122.18	325,328,122.18
512	Хуримтлагдсан үр дүн	-314,363,064.41	-38,986,087.60
51210	Өмнөх үеийн үр дүн	-314,363,064.41	-314,363,064.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	275,376,976.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	828,326,649.00	828,326,649.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,043,766,706.77	1,319,143,683.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	876,154,940.00	1,134,516,107.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,380,840.00	311,493,007.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,380,840.00	311,493,007.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,380,840.00	311,493,007.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,380,840.00	311,493,007.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	180,765,200.00	160,593,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	686,008,900.00	662,430,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,114,000.00	27,941,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,114,000.00	27,341,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	132,651,200.00	132,651,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,651,200.00	132,651,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	911,178,153.98	859,139,130.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	911,178,153.98	859,139,130.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	725,782,483.33	721,990,126.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,723,620.18	468,338,341.56
210101	Үндсэн цалин	277,088,619.45	363,970,407.02
210102	Нэмэгдэл	133,511,548.69	58,795,205.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,659,917.90	11,845,742.40
210104	Урамшуулал	32,463,534.14	33,726,986.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,124,728.17	60,580,795.29
210201	Тэтгэврийн даатгал	39,290,790.17	42,458,158.03
210202	Тэтгэмжийн даатгал	4,633,615.00	4,711,752.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,653,132.00	3,745,881.89
210204	Ажилгүйдлийн даатгал	864,611.00	876,977.16
210205	Эрүүл мэндийн даатгал	8,682,580.00	8,788,025.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,561,022.00	117,464,430.00
210301	Гэрэл, цахилгаан	4,183,220.00	2,865,748.00
210302	Түлш, халаалт	110,545,952.00	110,545,952.00
210303	Цэвэр, бохир ус	3,831,850.00	4,052,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,603,209.38	4,157,564.93
210401	Бичиг хэрэг	1,286,050.00	1,367,250.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,000.00	280,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	12,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	449,310.00	76,230.00
210408	Бараа материал акталсны зардал	1,437,849.38	1,772,084.93
2105	Нормативт зардал	46,324,043.00	18,031,935.00

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,200.00	168,500.00
210502	Хоол, хүнс	43,872,623.00	14,174,315.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,374,220.00	3,689,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	230,000.00	500,430.00
210604	Урсгал засвар	230,000.00	500,430.00
2107	Томилолт, зочны зардал	16,000.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	16,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,203,660.60	52,816,629.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	451,300.00	2,293,120.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	313,365.00	1,378,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,438,995.60	49,145,109.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,395,670.65	137,149,004.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,114,000.00	27,341,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,114,000.00	13,817,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	13,524,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,590,179.00	17,093,701.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,590,179.00	14,686,770.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,691,491.65	92,713,403.15
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,691,491.65	92,713,403.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-35,023,213.98</u>	<u>275,376,976.81</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-35,293,213.79</u>	<u>275,376,976.81</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	786,598,879.00	-279,077,380.62	1,037,324,620.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	7,530.00	7,530.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	529,803,122.18	786,598,879.00	-279,069,850.62	1,037,332,150.56
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-35,293,213.79	-35,293,213.79
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	828,326,649.00	-314,363,064.41	1,043,766,706.77
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	828,326,649.00	-314,363,064.41	1,043,766,706.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	529,803,122.18	828,326,649.00	-314,363,064.41	1,043,766,706.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	275,376,976.81	275,376,976.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	828,326,649.00	-38,986,087.60	1,319,143,683.58

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	866,774,100.00	825,430,031.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	866,774,100.00	825,430,031.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	686,008,900.00	662,430,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,114,000.00	30,348,831.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,114,000.00	27,341,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,006,931.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	132,651,200.00	132,651,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,651,200.00	132,651,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	865,374,200.00	815,705,531.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	865,374,200.00	815,705,531.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	679,978,529.35	678,556,526.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,899,223.21	468,338,343.73
210101	Үндсэн цалин	277,264,222.48	363,970,409.19
210102	Нэмэгдэл	133,511,548.69	58,795,205.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,659,917.90	11,845,742.40
210104	Урамшуулал	32,463,534.14	33,726,986.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,124,725.14	60,580,793.12
210201	Тэтгэврийн даатгал	42,274,225.01	42,458,157.62
210202	Тэтгэмжийн даатгал	3,244,750.78	4,775,877.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,912,570.96	3,681,755.67
210204	Ажилгүйдлийн даатгал	615,632.34	876,977.52
210205	Эрүүл мэндийн даатгал	8,077,546.05	8,788,024.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	118,561,022.00	117,464,430.00
210301	Гэрэл, цахилгаан	4,183,220.00	2,865,748.00
210302	Түлш, халаалт	110,545,952.00	110,545,952.00
210303	Цэвэр, бохир ус	3,831,850.00	4,052,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,382,300.00	3,263,300.00
210401	Бичиг хэрэг	200,000.00	200,000.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,000.00	280,000.00
210404	Ном, хэвлэл	85,000.00	85,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,667,300.00	2,048,300.00
2105	Нормативт зардал	41,101,874.00	18,757,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,100.00	125,100.00
210502	Хоол, хүнс	40,126,774.00	16,782,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,000.00	1,849,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	499,999.00	500,000.00
210604	Урсгал засвар	499,999.00	500,000.00

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	16,000.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	16,000.00	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	760,000.00	2,445,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	760,000.00	2,445,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,633,386.00	7,106,330.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,202,200.00	4,679,030.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,431,186.00	2,427,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,395,670.65	137,149,004.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,114,000.00	27,341,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,114,000.00	13,817,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	13,524,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,406,931.00
213304	Хөрөнгийн	00.00	2,406,931.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,590,179.00	14,686,770.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,590,179.00	14,686,770.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,691,491.65	92,713,403.15
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,691,491.65	92,713,403.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,399,900.00</u>	<u>9,724,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>1,399,900.00</u>	<u>9,724,500.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>1,399,900.00</u>	<u>9,724,500.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	1,399,900.00	9,724,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,399,900.00	9,724,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,399,900.00</u>	<u>-9,724,500.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	795,081,200.00	687,681,026.85	107,400,173.15	86.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	795,081,200.00	687,681,026.85	107,400,173.15	86.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	795,081,200.00	687,681,026.85	107,400,173.15	86.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	503,561,600.00	468,338,343.73	35,223,256.27	93.0
210101	Үндсэн цалин	315,145,300.00	363,970,409.19	-48,825,109.19	115.5
210102	Нэмэгдэл	118,390,000.00	58,795,205.78	59,594,794.22	49.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,160,000.00	11,845,742.40	5,314,257.60	69.0
210104	Урамшуулал	52,866,300.00	33,726,986.36	19,139,313.64	63.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,980,800.00	60,580,793.12	7,400,006.88	89.1
210201	Тэтгэврийн даатгал	47,837,500.00	42,458,157.62	5,379,342.38	88.8
210202	Тэтгэмжийн даатгал	5,035,400.00	4,775,877.78	259,522.22	94.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,027,800.00	3,681,755.67	346,044.33	91.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,006,700.00	876,977.52	129,722.48	87.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,073,400.00	8,788,024.53	1,285,375.47	87.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,151,200.00	117,464,430.00	14,686,770.00	88.9
210301	Гэрэл, цахилгаан	10,350,000.00	2,865,748.00	7,484,252.00	27.7
210302	Түлш, халаалт	110,546,000.00	110,545,952.00	48.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	11,255,200.00	4,052,730.00	7,202,470.00	36.0
2104	Хангамж, бараа материалын зардал	10,435,000.00	10,433,300.00	1,700.00	100.0
210401	Бичиг хэрэг	200,000.00	200,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	150,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,000.00	280,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	85,000.00	85,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	500,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,220,000.00	9,218,300.00	1,700.00	100.0
2105	Нормативт зардал	68,846,200.00	18,757,830.00	50,088,370.00	27.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,100.00	125,100.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	66,871,100.00	16,782,750.00	50,088,350.00	25.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,850,000.00	1,849,980.00	20.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	100,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	100,000.00	100,000.00	0.00	100.0

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6506400.00	6506330.00	70.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,079,100.00	4,079,030.00	70.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,427,300.00	2,427,300.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	795,081,200.00	795,081,200.00	0.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	662,430,000.00	662,430,000.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	662,430,000.00	662,430,000.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	132,651,200.00	132,651,200.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	132,651,200.00	132,651,200.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	39.00	39.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,941,900.00	27,941,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,941,900.00	27,941,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,341,900.00	27,341,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,341,900.00	27,341,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,817,400.00	13,817,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,524,500.00	13,524,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,348,831.00	30,348,831.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,348,831.00	30,348,831.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,341,900.00	27,341,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,006,931.00	3,006,931.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэн ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор С.Батжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэг нь “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйл ажиллагааг танхим болон зайны сургалтын хэлбэрийг хослуулан чанартай зохион байгуулж, хүүхдийн оюуны чадавхыг өндөржүүлэх хурд хүчний гайхамшиг спорт өрөлт тоглоомоор хөгжүүлж, эцэг, эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр хүүхэд бүрийг ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН болгон төлөвшүүлэх”-ийг эрхэм зорилгоо болгон анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэг үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/24 тоот тушаалаар цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт тавих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан томилж, 2021 оны ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг гаргаж ажилласан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэг нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 795,081.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,926.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,944.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 865,030.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 732,379.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс, 132,651.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр төсвөөс тодотголоор 795,081.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 30,348.8 мянган төгрөг, нийт 825,430.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 688,281.0 мянган төгрөгийг зарцуулж 109,807.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгөд улсын хөрөнгө оруулалтаар 301,750.3 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9,724.5 мянган төгрөгийн, хандив тусламж болон үнэ төлбөргүй хүлээн авсан 6,915.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,232.5 мянган төгрөг болж өмнөх оноос 4,999.3 мянган төгрөгөөр өссөн нь цар тахлын нөхцөл байдалтай уялдан хүнсний материал, ариун цэврийн хэрэгсэл, ариутгалын бодис нөөц бүрдүүлсэн байна.

Авлага, өглөгийн талаар:

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн, үлдэгдлийг баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэг нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 69,232.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,249,911.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	64,240.2	69,232.5	4,992.2
Үндсэн хөрөнгө	979,526.5	1,249,911.2	270,384.7
Нийт хөрөнгө	1,043,766.7	1,319,143.7	275,377.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,043,766.7	1,319,143.7	275,377.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,043,766.7	1,319,143.7	275,377.0

Бараа материалын дансны үлдэгдэл 69,232.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 4,992.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,249,911.2 мянган төгрөг болж 270,384.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд цэцэрлэгийн барилгад их засвар хийгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,319,143.7 мянган төгрөг болж 275,377.0 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нэмэгдэж, тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 799,370.7 мянган төгрөгөөр төлөвлөн, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бараа ажил үйлчилгээний зардалд 795,081.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвөөс 795,081.2 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 687,681.0 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 107,400.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 687,681.0 мянган төгрөг буюу 86.5 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт нийт 30,348.8 мянган төгрөгийн орлогоос 27,941.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,406.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 4,999.2 мянган төгрөгөөр өссөн нь хэдий 2021 оны 9 дүгээр сараас эхлэн сургалтын үйл ажиллагаа эхэлсэн боловч сурагчийн амралт эхэлж эцэг эхийн хүсэлтээр хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаж хүүхдийн тоо буурсан нь хүнсний материал, хичээл сургалт эхэлсэнтэй холбоотой хүүхдийн ариун цэврийн хэрэгсэл, цар тахлын улмаас ариутгалын бодис нөөцөлж бүрдүүлсэн зэрэг нь үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансанд 2021 онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан, ашиглагдаагүй 410.7 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1,733.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,608.4 мянган төгрөгийн хоол хүнсний материал, 240.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалын үлдэгдэлтэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,249,911.2 мянган төгрөг болж, 270,384.7 мянган төгрөгөөр өссөн нь цэцэрлэгийн А байр их засварт орж санхүүгийн тайланд тусгасан. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 301,750.3 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 9,724.5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 6,915.0 мянган төгрөг, дотооддоо шилжүүлгээр шилжүүлсэн 1,140.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан хөрөнгө байхгүй байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 10 нэр төрлийн 11,962.1 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 146 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,140.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,962.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,962.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийх алдаа зөрчил илрээгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 10 нэр төрлийн 11,962.1 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг цаашид ашиглагдах боломжгүй бол холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэг	1	11,962.1	-	-	-	-	-	-	1	11,962.1

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn